

Сэдэв: “Ойн менежментийн улсын ерөнхий төлөвлөгөө 2011-2015”

Захиалагч: Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Ойн газар

Гүйцэтгэгч: ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн, ойн нөөц, ой хамгааллын салбар

Бичвэр: Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Ойн газар, Геоэкологийн хүрээлэнгийн хооронд байгуулсан “Ойн менежментийн улсын ерөнхий төлөвлөгөөний төсөл” боловсруулах №4/07, 02/01 тоот гэрээний дагуу 2011-2015 онд хэрэгжүүлэх Ойн менежментийн улсын урөнхий төлөвлөгөөг холбогдох хууль, тогтоомж болон журам, зааврыг баримтлан, тус менежментийн төлөвлөгөөг хэлэлцсэн БОАЖЯ-ны Сайдын зөвлөлийн хуралдаан болон бусад семинар, зөвлөгөөнөөс гарсан санал, зөвлөмж, шийдвэрийг цаг тухайд нь тусгаж, шинэчлэн боловсруулсан болно.

Ойн менежментийн улсы ерөнхий төлөвлөгөөний зорилго:

Ойн менежментийн улсын ерөнхий төлөвлөгөө (цаашид “төлөвлөгөө” гэнэ)-ний үндсэн зорилго нь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлэх замаар ойн нөөцийн тогтвортой менежментийн үндсэн шаардлагуудыг ханган байгаль орчин, ойн талаар төрөөс баримтлах бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд

Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

Нэг. Уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамаарсан Монгол орны ойн сангийн өөрчлөлтийг тодорхойлж, ойн хөрс, ус хамгаалах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, ногоон бүс ба тусгай хамгаалалттай газар нутгийн ойн менежмент, ойн хууль, эрх зүйн орчныг сайжруулах,

Хоёр. Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хөнөөлт шавж, өвчний тархалтаас сэргийлэх, тэдгээртэй тэмцэх,

Гурав. Мод сөөгний үр бэлтгэх, тарьц суулгац үржүүлэх ажлыг эрчимжүүлж, гол мөрний эх, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбайг эхний ээлжинд ойжуулж, тал хээр, говь, цөлд хамгаалалтын ойн зурвас, төгөл, ногоон хаалт байгуулах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх;

Дөрөв. Ойн өсөлт, бүтээмжийг нэмэгдүүлэх модлогийн чанарыг сайжруулах зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээг зохих арга технологийн дагуу явуулах, жилд бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг тухайн ойн даацтай нь уялдуулах, ой модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх, ойн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах мод, модон бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах;

Тав. Ойн санг эзэмшиж буй нөхөрлөл, байгууллагуудын үйл ажиллагааг ойн удирдах болон мэргэжлийн байгууллагатай уялдуулах, дэмжлэг үзүүлэх, ойн мэргэжилтэн, судлаачдыг чадавхижуулах, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх механизмыг бий болгох, ойн салбарт хөрөнгө оруулалт хийх, шинэ техник, технологиор хангах, улмаар үйл ажиллагаа, үр дүнгийн хяналтыг сайжруулах;

Холбоо барих: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Баруун сэлбэ-15,
geoeco@magicnet.mn, Факс-976-11-321862, Эрдэмтэн нарийн бичгийн дарга-976-11-321750